

## ИСПАНИ - ХЭЭРИЙН ТУУЛАЙН ОРОН

*Л.Бэгзжав*

Испани улс бол Европ тивд Францын дараа орох хоёрдогч том орон бөгөөд Атлантын далай Газар дундын тэнгисийн дунд орших Иберийн хойгийн 5/6 хувийг эзлэх ба үлдсэн нэг хувийг Португали, Андорра улс эзэлдэг. Африкаас 21 км зайд Гибралтарийн хоолойгоор тусгаарлагддаг Испани улсыг “Европ, Африк, Латин Америкт нэвтрэх гүүр” гэж нэрлэдэг. Тэгээд ч Латин Америкийн Венесуэл, Аргентин, Боливи, Урагвай, Чили, Доминкан улсаас эхлээд Ази, Африк, Америк тивийн 30-аад орон испани хэлээр ярилцдаг билээ.

Испани улс нь манай улсаас 3 дахин бага буюу 506 мянган км<sup>2</sup> газар нутагтай, 16 дахин их буюу 40 сая хүн амтай юм.

Espana буюу Испани гэдэг нэрийг эртний Ромчууд Hispana, Грекчүүд Spania гэж дууддаг байсан нь хээрийн туулайн орон, туулайт газар гэсэн утгатай аж. Энэ нутагт колонийн газар байгуулах үед үй олон туулайтай байсан тул Span гэж нэрлэсэн нь хувирсаар Испани улсын нэр болжээ. <sup>1</sup>

Өөр нэгэн тайлбараар, Испаний баск үндэстний баск хэлний egrapa буюу хил, хязгаар, далай гэсэн үгнээс Испани улсын нэр үүсэлтэй ажээ. Энэ нь тухайн газрын газар зүйн нэр байснаа хожим өнөөгийн Испани улсын нэр болжээ.

Бас нэгэн тайлбар байдаг. Финик хэлний “булах” гэсэн утгатай үгийн утга шилжиж булсан эд баялаг, уурхайн баялаг гэсэн утгатай болжээ. Испани улсын орших Иберийн хойг алт, мөнгө, зэс зэрэг ашигт малтмал ихтэй тул финикчүүд эртнээс энэ эд баялагийн эзэн болохыг санаархаж “булагдмал эрдэнэ” буюу Испани гэдэг нэрийг өгсөн гэдэг.

Испаничууд бол Европын хамгийн өвөрмөц үндэстний нэг гэгддэгийн учир нь тэднийг эртний финик, грек, катаки, ром, жүрт,

<sup>1</sup>Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

ибер, мар, жүүд зэрэг олон үндэстнээс уг гарвалтай гэж үздэг. Ромын католик шашин шүтдэг Испаничууд бие даасан өвөрмөц ёс, зан заншил, хэл яриатай ард түмэн юм.

Жүрж, нимбэг, гүйлс, анар, инжир, алим, лийр, гадил, интоор, чавга зэрэг олон төрлийн жимс жимсгэний ургацаараа гайхуулдаг Испани орон эртнээс дарс үйлдвэрлэлээрээ дэлхийд Франц, Италитай өрсөлдсөөр ирсэн билээ. Нэн ялангуяа Испани улс “чидун жимсний хаант улс” гэж хол ойртоо зард гарчээ. Испанид чидун жимсний мод тариалсан нь лавтай 2000 гаруй жилийн түүхтэй гэлцдэг. Энх тайваны билэг тэмдэг болдог чидун жимсний модыг Испаничууд хүндэтгэн эрхэмлэдэг уламжлалтай агаад чидун жимсний тос тус улсын экспортын гол бүтээгдэхүүний нэг юм. Дэлхийн олон оронд чидун жимсний мод тариалдаг ч Испани улс энэ салбарт дэлхийд тэргүүлдэг. 1950 онд 194 тн чидун жимсний тос үйлдвэрлэж байсан бол одоо жилдээ 500 мянган тонноос давж, дэлхийн чидун жимсний тосны үйлдвэрлэлийн 40%-ийг гаргаж дэлхийд нэгдүгээрт орж байна.

Дашрамд Испани орны тухай зарим нэгэн тоо баримтыг 1999 оны “The World Almanac”<sup>2</sup> номноос сонирхуулбал:

#### Хүн ам

Нийт хүн ам	39,887,240
Нягтрал	77,6 хүн/км <sup>2</sup>
Хотынх	78,4%
Хөдөөгийнх	21,6%
Жилийн өсөлт	0,3%

#### Эдийн засаг

Үндэсний нийт бүтээгдэхүүн	593 тэрбэм ам.доллар
Нэг хүнд ногдох	15300 ам.доллар

#### Гадаад худалдаа:

Импорт	118,3 тэрбум ам.доллар
Экспорт	94,5 тэрбум ам.доллар

#### Худалдааны гол түнш

Европын нийтийн зах зээл	75%
Америк	5%

## Боловсрол, эмнэлэг

Бичиг үсэг мэдэх байдал	97%
Их дээд сургуулийн тоо	1415
Нэг өвчтөнд ногдох орны тоо	234:1
Нэг өвчтөнд ногдох эмчийн тоо	241:1

## Наслалт

Эмэгтэй	81
Эрэгтэй	75
Хүүхдийн эндэгдэл	6,7%

**ИШЛЭЛ**

1. Шизе гэгэ гомин зизинь. Бээжин 1986. 119-120-р тал
2. Himilce Novas, Rosemary E. Silva. Spain /Хятад хэлээр/ Гуанжоу. Гуандуны жуулчлал хэвлэлийн газар. 2001 оны 6-р сар. 8-9-р тал.